

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/5/НА-СТА-ТЕ3

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261628 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОР ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа	15
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө	17
3.5.2 Авлага	18
3.5.3 Урьдчилгаа	19
3.5.4 Бараа материал	19
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	20
3.5.6 Үндсэн хөрөнгө	20
3.5.7 Өр төлбөр	21
3.5.8 Засгийн газрын хувь оролцоо	22
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	22
3.6.1 Төсвийн төлөвлөлт	23
3.6.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт	23
3.6.3 Төсвийн гүйцэтгэл	23
3.6.4 Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл:	26
3.6.5 Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэрэгжилт:	26
3.6.6 Нэмэлт төсөв	28
3.6.7 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	28
4. АУДИТЫН ТАЙЛАН	29
4.1 Ерөнхий зүйл	29
4.2 Материаллаг байдал	29
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	29
4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	29
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	29
4.4 Дараагийн аудитаар анхаарах асуудал	32
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	33
5.1 Эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд	33
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:	33
5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил	34
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	36
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны нэгтгэл	36
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	40
6.4 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал	

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХД	Багахангай дүүрэг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХАБЭМТ	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
ЧД	Чингэлтэй дүүрэг



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА

2026.04.27 № 1147
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 143,229.4 сая төгрөгийн зөрчил бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Харьяа 163 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 116,586.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байгаатай холбоотой;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тайлант онд хэрэгжиж дууссан нийт 5,184.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний ажил дутуу хийгдсэн, 2014 оноос хэрэгжиж байгаа 17,240.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, санхүүжилт нь 90 хувь олгогдсон 1 төсөл арга хэмжээ, нийт 22,424.4 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, удаашралтай;

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж тайлант онд ашиглалтад оруулсан 4,218.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилгыг орон нутгийн өмчит шилжүүлэх Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 582, 789 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлээгүй, ашиглагч байгууллагуудад шилжүүлж бүртгүүлэх арга хэмжээ аваагүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.10, 22 дугаар зүйлийн 22.1, Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 2 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8, 29.9.13, 30.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1, 208 дугаар зүйлийн 208.1, 211 дүгээр зүйлийн 211.1, Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.3, мөн 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.7, 6.4, 6.11, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-т заасан холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн", "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын болон Засаг даргын нөөц сангаас 16,152.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 13,640.0 сая төгрөг, төсвийн жилийн явцад Монгол Улсын Их хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон Олон Улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 26.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,335.9 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 1,068.2 сая төгрөгийн хандив тусламж, нийт 33,222.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 31,796.7 сая төгрөгийг зарцуулж, 1,426.0 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу халамжийн сангаас халамжийн үйлчилгээнд улсын төсвөөс 2,599,310 иргэнд 2,413,186.9 сая төгрөг, сангийн үйл ажиллагааны зардалд 267.8 сая төгрөг, нийт 2,413,454.7 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс 1,353,720 хүүхдэд нийт 1,549,749.2 сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид олгосон нь нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн зардлын 64.2 хувийг эзэлж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээний (Дэмжих төв) үнэ тариф"-г шинэчлэн тогтоосны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шаардлага хангасан 12 аж ахуйн нэгж, байгууллагад нийт 3,902.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр, эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор “Дагалдан ажиллаж хөдөлмөрт шилжих нь” туршилтын хөтөлбөрийг баталж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 698.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засгийн газрын 2025 оны “Хөрөнгө гаргах тухай” 208, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 40, “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 41 дүгээр тогтоолуудаар Хөвсгөл аймгийн “Шинэ мөрөн” төвийн худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд зориулж 5,200.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 4,862.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнасан байна. Тухайлбал: “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 85.3 хувьтай, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5 зорилго, 9 зорилтын 21 арга хэмжээнээс 20 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, Засгийн газрын “2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 62 зорилт, 104 арга хэмжээний тайлант оны биелэлт 75.5 хувьтай байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Хуримтлалын сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх, Монгол улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх үйл ажиллагааг 2025 оны 08 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж ажиллажээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.3 дахь заалтуудын дагуу Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монголбанк хооронд 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 98,А/132,2025/195,0525/183 дугаартай “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г байгуулж, хуримтлалын сангаас тайлант онд 3,664 өрхөд 462,314.9 сая төгрөгийг ипотекийн зээлийн эх үүсвэрт олгосноос орон нутгийн 1,441 өрхөд 169,258.9 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	476,790,229.9	673,542,101.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	29,015,189.3	30,777,725.1
АВЛАГА	366,770,219.3	551,343,230.5
УРЬДЧИЛГАА	96,038.8	888,100.2
БАРАА МАТЕРИАЛ	12,130,140.7	12,136,625.1
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	68,778,641.7	78,396,420.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	202,617,741.4	225,355,594.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	202,617,741.4	225,355,594.3
Биет хөрөнгө	186,753,542.2	202,793,685.5
Биет бус хөрөнгө	15,864,199.2	22,561,908.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	679,407,971.3	898,897,696.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,528,912.9	32,039,259.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,914,846.7	21,561,598.0
Өглөг	1,460,971.2	10,070,831.4
Урьдчилж орсон орлого	17,453,875.4	11,185,527.7
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,614,066.2	10,477,661.2
Урт хугацаат зээл	12,614,066.2	10,477,661.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	647,879,058.4	866,858,437.0
Засгийн газрын хувь оролцоо	647,879,058.4	866,858,437.0
Засгийн газрын оруулсан капитал	62,889,747.2	62,185,155.8
Хуримтлагдсан үр дүн	544,344,023.2	765,729,714.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,645,288.1	38,943,567.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	679,407,971.3	898,897,696.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,085,327,646.0	4,524,401,987.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	225,222,521.5	4,524,401,987.5
Нийтлэг татварын бус орлого	225,222,521.5	248,288,163.6
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		4,276,113,823.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,860,105,124.6	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,872,707,805.3	4,291,343,213.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,872,707,805.3	4,291,343,213.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,292,250.5	289,854,548.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,939,606.1	184,221,942.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,450,157.3	22,387,023.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,539,247.7	11,428,017.3
Хангамж, бараа материалын зардал	6,404,253.7	6,084,498.4
Нормативт зардал	7,844,071.2	9,622,350.5
Эд хогшил, урсгал засварын зардал	2,246,881.1	1,593,363.2
Томилолт, зочны зардал	1,576,871.4	1,384,118.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,192,187.5	29,170,076.8
Бараа үйлчилгээний бусад зардал	23,098,974.4	23,963,157.9

ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	1,174,973,967.8	1,452,499,883.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,450,441,587.0	2,548,988,782.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	212,619,840.7	233,058,773.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,496.8	34,498.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,670,886.5	13,979,462.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	186,950,451.0	219,113,800.7

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	460,624,159.9	460,624,15.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	490,676.3	490,676.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,114,836.1	461,114,836.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(521,186.8)	(521,186.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	334,958.0	334,958.0
Тайлант үеийн үр дүн	186,950,451.0	186,950,451.0
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	647,879,058.4	647,879,058.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,597,956.8	1,597,956.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	649,477,015.2	649,477,015.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,258,805.0)	(1,258,805.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(373,264.6)	(373,264.6)
Тайлант үеийн үр дүн	219,013,491.4	219,013,491.4
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	866,858,436.9	866,858,436.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,156,112,049.8	4,685,408,320.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	267,759,006.9	4,685,408,320.2
Нийтлэг татварын бус орлого	267,759,006.9	408,327,979.9
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		4,277,080,340.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,888,353,043.0	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,096,770,782.5	4,694,051,323.4
УРСГАЛ ЗАРДАЛ	4,096,770,782.5	4,694,051,323.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	233,327,633.1	269,533,618.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,273,202.2	183,160,389.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,565,303.7	22,334,547.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,535,249.0	11,573,205.1
Хангамж, бараа материалын зардал	4,014,430.1	3,948,754.6
Нормативд зардал	8,514,500.7	9,323,510.5
Эд хогшил, урсгал засварын зардал	3,074,448.8	3,074,448.8
Томилолт, зочны зардал	1,490,786.1	1,336,624.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,436,481.2	31,288,987.8
Бараа үйлчилгээний бусад зардал	8,423,231.2	5,022,335.7
ТАТААС	1,175,690,962.4	1,453,406,478.0

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,687,752,187.1	2,971,111,227.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	59,341,267.3	(8,643,003.2)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (V)		14,000.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	38,660,259.6	45,406,148.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,660,259.6	45,406,148.5
Дотоод эх үүсвэрээр	38,660,259.6	45,406,148.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(38,660,259.6)	(45,392,148.5)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(9,594,417.5)	55,797,687.6
Бусад эх үүсвэр	0.0	52,686,989.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	9,547,307.0	(3,133,121.0)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	47,110.6	22,423.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	11,086,590.2	1,762,535.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,928,599.1	29,015,189.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,015,189.3	30,777,725.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,408,966,475,800.00	4,411,006,147,838.11	(2,039,672,038.11)	100.0
12	Татварын бус орлого	4,408,966,475,800.00	4,411,006,147,838.11	(2,039,672,038.11)	100.0
120	Нийтлэг татварын бус орлого	63,742,617,400.00	211,161,861,870.33	(147,419,244,470.33)	331.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	58,251,542,700.00	199,523,323,606.51	(141,271,780,906.51)	342.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	5,491,074,700.00	11,638,538,263.82	(6,147,463,563.82)	212.0
122	Тусламжийн орлого	4,345,223,858,400.00	4,199,844,285,967.78	145,379,572,432.22	96.7
122001	Хандив тусламж /дотоод/	3,035,121,100.00	3,634,487,292.70	(599,366,192.70)	119.7
122005	Төсвөөс санхүүжих	4,342,188,737,300.00	4,196,209,798,675.08	145,978,938,624.92	96.6
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,494,648,671,300.00	4,261,089,068,286.08	233,559,603,013.92	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,404,934,847,500.00	4,225,762,519,921.47	179,172,327,578.53	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,011,033,600.00	257,140,978,544.49	44,870,055,055.51	85.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,983,554,300.00	174,972,575,631.52	15,010,978,668.48	92.1
210101	Үндсэн цалин	95,737,429,300.00	91,858,366,041.68	3,879,063,258.32	95.9
210102	Нэмэгдэл	51,711,852,600.00	45,295,149,045.45	6,416,703,554.55	87.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,703,167,000.00	23,573,783,142.57	1,129,383,857.43	95.4
210104	Урамшуулал	17,831,105,400.00	14,245,277,401.82	3,585,827,998.18	79.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,639,878,300.00	21,344,442,119.02	2,295,436,180.98	90.3
210201	Тэтгэврийн даатгал	16,084,975,100.00	14,653,752,955.03	1,431,222,144.97	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,891,144,200.00	1,738,955,451.53	152,188,748.47	92.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	957,831,500.00	878,867,375.05	78,964,124.95	91.8
210204	Ажилгүйдлийн даатгал	947,924,700.00	810,952,032.90	136,972,667.10	85.6
210205	Эрүүл мэндийн даатгал	3,758,002,800.00	3,261,914,304.51	496,088,495.49	86.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,860,879,200.00	11,235,278,765.16	1,625,600,434.84	87.4
210301	Гэрэл, цахилгаан	2,905,362,200.00	2,257,760,932.58	647,601,267.42	77.7
210302	Түлш, халаалт	7,533,800,300.00	6,873,673,786.28	660,126,513.72	91.2
210303	Цэвэр, бохир ус	1,122,770,400.00	853,371,878.62	269,398,521.38	76.0
210304	Байрны түрээс	1,298,946,300.00	1,250,472,167.68	48,474,132.32	96.3
2104	Хангамж, бараа материалын зардал	4,701,819,800.00	3,215,759,805.18	1,486,059,994.82	68.4
210401	Бичиг хэрэг	1,155,509,100.00	760,790,049.47	394,719,050.53	65.8
210402	Тээвэр, шатахуун	1,123,875,100.00	787,355,723.94	336,519,376.06	70.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	763,697,300.00	480,415,894.01	283,281,405.99	62.9
210404	Ном, хэвлэл	294,244,300.00	169,219,662.00	125,024,638.00	57.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	269,924,000.00	121,122,251.76	148,801,748.24	44.9

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,094,570,000.00	896,856,224.00	197,713,776.00	81.9
2105	Нормативд зардал	11,693,805,000.00	8,850,199,777.76	2,843,605,222.24	75.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,905,590,500.00	986,814,907.97	918,775,592.03	51.8
210502	Хоол, хүнс	7,909,432,100.00	6,516,067,500.79	1,393,364,599.21	82.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,878,782,400.00	1,347,317,369.00	531,465,031.00	71.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,295,904,100.00	1,770,916,040.84	524,988,059.16	77.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	348,419,100.00	325,841,190.00	22,577,910.00	93.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	323,324,300.00	100,537,650.00	222,786,650.00	31.1
210604	Урсгал засвар	1,624,160,700.00	1,344,537,200.84	279,623,499.16	82.8
2107	Томилолт, зочны зардал	1,707,903,600.00	1,169,934,585.87	537,969,014.13	68.5
210701	Гадаад албан томилолт	149,914,900.00	149,088,450.53	826,449.47	99.4
210702	Дотоод албан томилолт	1,552,453,000.00	1,015,422,000.34	537,030,999.66	65.4
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,535,700.00	5,424,135.00	111,565.00	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,442,464,300.00	31,923,276,365.60	19,519,187,934.40	62.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,352,252,200.00	27,283,695,635.15	17,068,556,564.85	61.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	305,187,600.00	111,340,400.00	193,847,200.00	36.5
210803	Даатгалын үйлчилгээ	184,672,200.00	137,540,036.10	47,132,163.90	74.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,971,200.00	32,456,282.46	16,514,917.54	66.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	11,880,100.00	2,734,080.00	9,146,020.00	23.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,265,055,500.00	4,242,973,335.24	2,022,082,164.76	67.7
210807	Газрын төлбөр	97,146,200.00	55,719,431.20	41,426,768.80	57.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34,890,700.00	12,402,693.45	22,488,006.55	35.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	142,408,600.00	44,414,472.00	97,994,128.00	31.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,684,825,000.00	2,658,595,453.54	1,026,229,546.46	72.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	627,954,100.00	402,081,398.14	225,872,701.86	64.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,056,870,900.00	2,256,514,055.40	800,356,844.60	73.8
212	ТАТААС	1,453,556,212,200.00	1,453,409,764,475.78	146,447,724.22	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,453,556,212,200.00	1,453,409,764,475.78	146,447,724.22	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,453,556,212,200.00	1,453,409,764,475.78	146,447,724.22	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,649,367,601,700.00	2,515,211,776,901.20	134,155,824,798.80	94.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,173,197,500.00	8,062,092,305.00	111,105,195.00	98.6
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,008,125,400.00	8,008,125,400.00	-	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	165,072,100.00	53,966,905.00	111,105,195.00	32.7

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,641,194,404,200.00	2,507,149,684,596.20	134,044,719,603.80	94.9
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,258,095,600.00	37,258,095,600.00	-	100.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,512,669,887,000.00	2,413,186,796,903.94	99,483,090,096.06	96.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	564,796,500.00	369,301,661.00	195,494,839.00	65.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	84,896,877,600.00	51,407,646,512.49	33,489,231,087.51	60.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,600,180,900.00	3,351,825,906.41	248,354,993.59	93.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,001,552,600.00	835,367,497.36	166,185,102.64	83.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,203,014,000.00	740,650,515.00	462,363,485.00	61.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,728,100,000.00	38,459,669,448.40	10,268,430,551.60	78.9
220001	Барилга байгууламж	35,272,300,000.00	25,015,785,594.00	10,256,514,406.00	70.9
221001	Их засвар	1,220,200,000.00	1,216,063,290.40	4,136,709.60	99.7
222001	Тоног төхөөрөмж	12,235,600,000.00	12,227,820,564.00	7,779,436.00	99.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,985,723,800.00	(3,133,121,083.79)	44,118,844,883.79	(7.6)
230001	Эргэж төлөгдөх зээл	40,985,723,800.00	(3,133,121,083.79)	44,118,844,883.79	(7.6)
8	ЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(85,682,195,500.00)	149,917,079,552.03	(235,599,275,052.03)	(175.0)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85,682,195,500.00	(149,917,079,552.03)	235,599,275,052.03	(175.0)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	85,682,195,500.00	(149,917,079,552.03)	235,599,275,052.03	(175.0)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,352,658,391.03	(24,352,658,391.03)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,432,404,154.31	(29,432,404,154.31)	-
6	БАЙГУУЛЛАГЫН ТОО	164	164	-	100.0
61	Төсвийн байгууллага	164	164	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4,874	4859	15	99.6
620001	Удирдах ажилтан	261	248	13	95.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3,801	3827	(26)	100.0
620003	Үйлчлэх ажилтан	809	783	26	96.7
620004	Гэрээт ажилтан	3	1	2	33.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	33,222,783,737.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,222,783,737.26
122	Тусламжийн орлого	33,222,783,737.26
1221	Хандив тусламж /дотоод/	33,222,783,737.26
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,222,783,737.26
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,068,203,376.00
350012	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	26,440,500.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,152,125,537.17
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,640,080,827.12
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,335,933,496.97
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,796,760,819.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,796,760,819.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,329,256,125.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,111,552,104.02
210101	Үндсэн цалин	1,924,451,920.68
210102	Нэмэгдэл	4,610,323,549.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	509,770,330.36
210104	Урамшуулал	985,451,428.25
210105	Гэрээт ажлын хөлс	81,554,875.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	974,339,986.68
210201	Тэтгэврийн даатгал	710,601,831.96
210202	Тэтгэмжийн даатгал	71,412,873.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,666,063.40
210204	Ажилгүйдлийн даатгал	32,511,764.20
210205	Эрүүл мэндийн даатгал	123,147,453.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	295,092,694.24
210301	Гэрэл, цахилгаан	76,876,253.77
210302	Түлш, халаалт	162,558,691.21
210303	Цэвэр, бохир ус	29,217,749.26
210304	Байрны түрээс	26,440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	749,663,458.41
210401	Бичиг хэрэг	207,282,530.00
210402	Тээвэр, шатахуун	241,898,014.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,887,750.95
210404	Ном, хэвлэл	85,754,210.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,408,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	168,432,033.46
2105	Нормативд зардал	482,026,026.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,138,758.07
210502	Хоол, хүнс	418,527,870.62
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,359,398.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,375,820.24
210601	Багаж, техник, хэрэгсэл	581,563,865.24
210602	Тавилга	37,431,600.00
210604	Урсгал засвар	581,380,355.00
2107	Томилолт, зочны зардал	144,739,965.00
210701	Гадаад албан томилолт	16,501,400.00
210702	Дотоод албан томилолт	128,238,565.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,281,533,904.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,241,256,796.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,883,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	449,110.00

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,158,802.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,776,700.00
210807	Газрын төлбөр	986,896.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,089,932,165.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,136,768,813.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	953,163,352.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,467,504,694.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,467,504,694.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	553,594,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,565,054.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,813,889,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	82,456,540.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,426,022,918.11
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,426,022,918.11)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,426,022,918.11)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилгыг “Гэр бүл, хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан уялдаатай цогц бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.” гэж тодорхойлжээ.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал:

- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны үйл ажиллагаанд хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, яамны санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын бүлгүүдийн хөгжил, оролцоог хангах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбар дундын гэр бүлд ээлтэй цогц бодлого боловсруулж, хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих;
- Хөдөлмөрийн зах зээлийн зөв, оновчтой бодлого боловсруулж, гэр бүлд ээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх, хөдөлмөрийн хууль тогтоомж, цалин хөлсний бодлого зохицуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт болон бусад хамтын ажиллагааг хангах, салбарын хууль тогтоомж, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хяналт тавих;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзсан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах;
- Нийгмийн халамжийн үйлчилгээний хууль эрх орчныг шинэчилж, боловсронгуй болгох, нийгмийн халамжийн үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, орон нутаг, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт чиглүүлэх замаар нийгмийн халамж, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх;
- Салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулахад судалгаа, шинжилгээ, бодлогын удирдамжаар хангах, салбарын санхүү, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл, төсөв боловсруулах, батлуулах, хөрөнгө оруулалт, төсвийн шинжилгээ хийх, салбар хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх;

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн боловсруулж, стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тодорхойлон ажилласан байна.

Тайлант хугацаанд ТЭЗ-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль;
- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл “Баялгийн сангийн эх үүсвэр”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;

- Засгийн газрын 2025 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоол;
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйл "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр";
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгавар.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын хорооны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 2025/002 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу ГБХНХЯ болон харьяа АНҮТ, ХХҮЕГ, ХБХХЕГ-ын ХЭДС, ХГБХХЕГ-ын ХАБЭМТ, Өнөр бүл хүүхдийн төв, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Хөвсгөл, Говьсүмбэр, Сүхбаатар аймаг болон БХД, НД-ийн харьяа байгууллагуудад хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийсэн байна. Хяналт шалгалтаар нийт 48.7 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 805.8 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэн, 6.0 сая төгрөгийн 24 заалт бүхий 18 зөвлөмж өгсөн байна.

Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь 2025 онд 5 аймаг, 2 дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст дотоод үйл ажиллагаа, төсвийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан, нийгмийн халамжийн сангийн бүрдүүлэлт зарцуулалтад хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөний 85.1 хувийг хэрэгжүүлж ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 219,489.7 сая төгрөгөөр буюу 32.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /нэмэгдсэн +, буурсан - /
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	29,015.2	30,777.7	1,762.5
Авлага	366,770.3	551,343.2	184,572.9
Урьдчилгаа	96.0	888.1	792.1
Бараа материал	12,130.1	12,136.6	6.5
Бусад эргэлтийн хөрөнгө	68,778.6	78,396.4	9,617.8
Үндсэн хөрөнгө	202,617.7	225,355.6	22,737.9
Нийт хөрөнгө	679,407.9	898,897.6	219,489.7
Өр төлбөр	31,528.9	32,039.2	510.3
Засгийн газрын хувь оролцоо	647,879.0	866,858.4	218,979.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	679,407.9	898,897.6	219,489.7

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үлдэгдлээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данс байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,777.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,762.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	3.4	0.0	(3.4)
Төгрөг	3.4	0.0	(3.4)
Банканд байгаа бэлэн мөнгө	28,999.7	30,750.3	1,755.4
Төрийн сангийн харилцах	28,987.0	30,746.7	1,759.7
Арилжааны банк дахь харилцах	7.7	3.5	(4.1)
Гадаад валют	5.0	15.3	10.3
Арилжааны банк дахь харилцах	5.0	15.3	10.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	12.0	12.1	0.1
Дүн	29,015.2	30,777.7	1,762.5

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,762.5 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2¹ дүгээр зүйлийн 21².2.1 дэх заалтад заасны дагуу Хүүхдийн төлөө санд авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого өмнөх оноос 5,079.8 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд Дархан аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн арилжааны банкны үлдэгдэл 3.5 сая төгрөг, гадаад валютын арилжааны харилцах дансны 15.3 сая төгрөгийн үлдэгдэл нь БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явсан иргэний үйлчилгээний хураамжийн орлого, төрийн сангийн харилцах дансанд хөрөнгө оруулалтын ажлын барьцааны 1,175.1 сая төгрөг, техник хяналтын зардлын 151.4 сая төгрөг, Хүүхдийн төлөө сангийн 29,420.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 5,420.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү тооцож олгосон, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу суутгасан зэрэг нийт 921.5 сая төгрөг; /Булган аймгийн ХХҮГ 13.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ХХҮГ 1.4 сая төгрөг, Дорноговь аймгийн ХХҮГ 3.3 сая төгрөг, Нийслэлийн ХХҮГ 37.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 19.5 сая төгрөг, Ховд аймгийн ХХҮГ 21.7 сая төгрөг, Хөвсгөл аймаг 1.8 сая төгрөг, Орхон аймгийн ХХҮГ 6.0 сая, Өвөрхангай аймаг 4.0 сая төгрөг, АНУТөв 35.3 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ХХҮГ 0.5 сая төгрөг, Дорнод аймгийн ХХҮГ 0.4 сая төгрөг, Өмнөговь аймгийн ХХҮГ 4.3 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ХХҮГ 0.2 сая төгрөг, Нийслэлийн ХГБХХГ 252.4 сая төгрөг, Ховд аймгийн ХГБХХГ 93.0 сая төгрөг, Дорнод аймгийн ХГБХХГ 23.6 сая төгрөг, ХГБХХЕГ 14.8 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХГБХХГ 6.6 сая төгрөг, Төв аймгийн ХГБХХГ 5.8 сая төгрөг, Завхан аймгийн ХГБХХГ 5.3 сая төгрөг, Хан-Уул дүүргийн ХГБХХХ 5.6 сая төгрөг, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 1.8 сая төгрөг, Багануур дүүргийн ХГБХХХ 1.4 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ 1.1 сая төгрөг, Архангай аймгийн ХГБХХГ 0.8 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ХГБХХГ 0.5 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 0.3 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ХГБХХГ 0.1 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн НДГ 46.3 сая төгрөг, Дорнод аймгийн НДГ 23.8 сая төгрөг, Говь-Алтай аймгийн НДГ 10.6 сая төгрөг, Орхон аймгийн НДГ 7.1 сая төгрөг, Булган аймгийн НДГ 6.4 сая төгрөг, Увс аймгийн НДГ 3.0 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн НДГ 2.8 сая

төгрөг, НДҮЗ-ийн АА 2.7 сая төгрөг, Хан-Уул дүүргийн НДГ 2.4 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн НДГ 1.8 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн НДГ 0.8 сая төгрөг, НДЕГ-ын дэргэдэх МТТ 0.2 сая төгрөг, ХБХХЕГ 32.7 сая төгрөг, СЗСҮТ 55.8 сая төгрөг, ХБХСЗХТ 34.5 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ХБХХТөв 33.9 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХБХХТөв 18.6 сая төгрөг, Дорнод аймгийн ХБХХТөв 16.7 сая төгрөг, ХБИХЭДТ 11.7 сая төгрөг, ХХСХХТ 5.3 сая төгрөг, Дундговь аймгийн ХБХХТөв 1.6 сая төгрөг, ХАХНХССХ 39.9 сая төгрөг/

- Батлагдсан төсвийг нийт 637.6 сая төгрөгөөр зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан, ажлын гүйцэтгэлтэй уялдуулаагүй санхүүжилтийг олгосон; /Орхон аймгийн ХХҮГ 4.0 сая, Завхан аймгийн ХХҮГ 6.0 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 30.9 сая төгрөг, ХХҮЕГ 18.4 сая төгрөг, БЗД ХХҮГ 36.0 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 206.8 сая төгрөг, Дундговь аймгийн ХГБХХГ 15.6 сая төгрөг, Баянгол дүүргийн ХГБХХХ 12.1 сая төгрөг, Баянзүрх дүүргийн ХГБХХХ 11.0 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ХГБХХХ 4.2 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ХГБХХХ 1.9 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 0.3 сая төгрөг, НДЕГ 103.0 сая төгрөг, ГБХНХЯ 187.4 сая төгрөг/
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 623.2 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн; /ХХҮЕГ 36.9 сая төгрөг, БНСУ дахь ХНХҮТ 24.3 сая төгрөг, Завхан аймгийн ХХҮГ 2.4 сая төгрөг, Нийслэлийн ХХҮГ 47.9 сая төгрөг, ХГБХХЕГ 181.0 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 143.4 сая төгрөг, Налайх дүүргийн ХГБХХХ 8.4 сая төгрөг, Орхон аймгийн ХГБХХГ 0.5 сая төгрөг, Өмнөговь аймгийн НДГ 69.0 сая төгрөг, Увс аймгийн НДГ 29.5 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн НДГ 16.7 сая төгрөг, НДЕГ 14.4 сая төгрөг, Булган аймгийн НДГ 0.7 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн НДГ 8.7 сая төгрөг, Багануур дүүргийн НДГ 3.8 сая төгрөг, ГБХНХЯ 35.8 сая төгрөг/
- Байгууллагын дансанд төвлөрүүлсэн 32.0 сая төгрөгийн орлогын дансны бичилтийг буруу хийж зардлыг бууруулан тайлагнасан. /Чингэлтэй дүүргийн НДГ/
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 128ШШ20250370, дүүргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2025 оны 197ШШ2025/16317 тоот шүүхийн шийдвэрүүдээр ажилдаа эргэн орсон албан хаагчдад нийт 36.8 сая төгрөгийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй, байгууллагын төсвөөс төлсөн. /ХХҮЕГ 36.8 сая төгрөг/

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 551,343.2 сая төгрөг болж, өмнөх оноос 184,573.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	108.8	130.7	21.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	431.9	535.0	103.1
Татаас, санхүүжилтийн авлага	212,324.2	417,012.3	204,688.1
Зээлийн хүүгийн авлага	226.6	129.6	(97.0)
Бусад авлага	9,783.2	10,195.0	411.8
Байгууллагаас авах авлага	9,479.3	9,674.9	195.6
Хувь хүмүүсээс авах авлага	303.9	520.2	216.2
Зээлийн авлага	143,895.3	123,340.6	(20,554.8)
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	110,895.3	110,340.6	(554.8)
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	33,000.0	13,000.0	(20,000.0)
Дүн	366,770.2	551,343.2	184,573.0

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 184,573.0 сая төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудын татаас санхүүжилтийн авлага 204,688.1 сая төгрөгөөр нэмэгдэж, ХЭДС-гийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 20,000.0 сая төгрөгөөр буурсантай тус тус холбоотой байна

Нийт авлага дансны үлдэгдлийн 417,012.3 сая төгрөг буюу 75.6 хувийг татаас санхүүжилтийн авлага, 123,340.6 сая төгрөг буюу 22.4 хувийг ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэг болон зээлийн авлага, 10,990.1 сая төгрөг буюу 2.0 хувийг бусад байгууллагын авлага тус тус эзэлж байна.

Татаас, санхүүжилтийн авлага дансанд ХЭДС болон харьяа 4 байгууллагын хөтөлбөр арга хэмжээний үлдэгдэл 413,945.8 сая төгрөг, НДГ 0.6 сая төгрөг, ХГБХХЕГ-ын харьяа 12 байгууллагын 230.2 сая төгрөг, ХХҮЕГ-ын харьяа 23 байгууллагын 980.3 сая төгрөг, ГБХНХЯ-ы 15.6 сая төгрөг, ХАБЭМТ-ийн 828.3 сая төгрөг, ХБХХЕГ-ын харьяа 5 байгууллагын 978.6 сая төгрөг, ХНХСҮСХ-ийн 32.9 сая төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулж бүртгэсэн байна.

Авлага дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай, татан буугдсан Анод банкны дамжуулах зээлдүүлэх гэрээгээр 800.0 сая төгрөг, Капитал банкнаас авах 3,829.0 сая төгрөг, Оёдлын нэгдсэн холбооноос авах 14,459.7 сая төгрөг, ХЭДС-аас санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онуудад орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн 14,830.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад авлагын данстай холбоотой 21,015.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ХЭДС-ийн дамжуулан зээлээр олгосон зээлийн өмнөх оны авлагын үлдэгдлээс 5.8 хувь буюу 1,180.1 сая төгрөг барагдаж, нийт 19,088.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй; /ХЭДС/
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам"-ыг үндэслэн 2003-2017 онд олгосон зээлээс нийт 11 иргэн, аж ахуй нэгжид олгосон жижиг зээлийн хугацаа хэтэрсэн Шүүхийн шийдвэртэй 429.0 сая төгрөгийн авлагаас тайлант онд 7.3 хувь буюу 31.5 сая төгрөгийг барагдуулж, 397.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй. /ХЭДС/
- Авлагын 116.2 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /АНҮТ 11.4 сая төгрөг, ХУД 10.6 сая төгрөг, Төв аймгийн ХХҮГ 1.0 сая төгрөг, ХХХСХТ 1.0 сая төгрөг, Нийслэлийн ХЭДС 69.5 сая төгрөг, Төв аймгийн ХЭДС 22.7 сая төгрөг/
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг зөрчин 3 албан хаагчид байрны барьцааны төлбөр 94.3 сая төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдөр зарцуулж, авлага үүсгэсэн. /БНСУ дахь ХНХҮТ/
- Олон жил болсон 1,216.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохин байгуулан ажиллаагүй; /Ховд аймгийн ХГБХХГ 4.5 сая, Дундговь аймгийн ХЭДС 275.6 сая төгрөг, Завхан аймгийн ХЭДС 624.8 сая төгрөг, Орхон аймгийн ХЭДС 33.4 сая төгрөг, ХУД-ийн ХЭДС 20.8 сая төгрөг, БНД-ийн ХЭДС 2.6 сая төгрөг, БЗД-ийн ХЭДС 2.9 сая төгрөг, НД-ийн ХЭДС 3.0 сая төгрөг, БГД-ийн ХЭДС 17.8 сая төгрөг, БХД-ийн ХЭДС 3.8 сая төгрөг, СХД-ийн ХЭДС 47.3 сая төгрөг, Нийслэлийн ХЭДС 42.5 сая төгрөг, ХАБЭМТ 48.2 сая төгрөг, ОУХНЦ-50.8, Орхон ХГБХХГ-9.9, БЗД-ийн ХГБХХХ 1.3 сая, Архангай аймгийн НДГ 2.9 сая төгрөг, БХД-ийн НДГ 9.0 сая төгрөг, БЗД-ийн НДГ 2.8 сая төгрөг, БГД-ийн ХЭДС 11.0 сая төгрөг, СБД-ийн ХЭДС 0.4 сая төгрөг, ЧД-ийн ХЭДС 0.9 сая төгрөг, БХД-ийн ХЭДС 0.6 сая төгрөг/
- "Файбер троника" ХХК-ас авах авлагыг 41.3 сая төгрөгийн протезын түүхий эдээр барагдуулан тооцоог хаасныг цахим төлбөрийн и-баримтаар баталгаажуулаагүй. /СЗСҮТ/

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 888.1 сая төгрөг болж, өмнөх оноос 792.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	96.0	888.1	792.1
Дүн	96.0	888.1	792.1

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд ГБХНХЯ-ы "Өгөгдлийн шинжилгээний үйл ажиллагаа" зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлбөрт олгосон 505.6 сая төгрөг, ХГБХХЕГ-ын "Гэр бүлийн вертуал зөвлөх AR контент үйлчилгээ"-ний урьдчилгаа төлбөрт төлсөн 310.9 сая төгрөг болон харьяа байгууллагын 3.4 сая төгрөг, ХХҮЕГ-ын шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 15.4 сая төгрөг, Ховд аймгийн ХХҮГ-ын өмнөх онд үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд олгосон 4.9 сая төгрөг, Хэнтий аймгийн ХГБХХГ-ын 2021 онд "Булган шонхор" ХХК-ар Залуучууд хөгжлийн төвд их засварын ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч компаниас шалтгаалан их засварын ажлын төлбөр 52.7 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 12,136.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,054.3	1,106.2	51.9
Дуусаагүй үйлдвэрлэл	71.8	110.7	38.9
Бэлэн бүтээгдэхүүн	37.2	61.1	23.9
Хангамжийн материал	10,896.7	10,841.9	(54.8)
Мал амьтад	70.1	16.7	(53.4)
Дүн	12,130.1	12,136.5	6.4

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 6.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 20,515.0 сая төгрөгийн бусад хангамжийн бараа материалын худалдан авалт хийж, 20,508.5 сая төгрөгийн зарцуулалттай тус тус холбоотой байна.

Бараа материалын үлдэгдлийн 5,937.7 сая төгрөг буюу 49.0 хувийг бусад хангамжийн материал, 3,401.3 сая төгрөг буюу 28.0 хувийг аж ахуйн материал, 1,106.2 сая төгрөг буюу 9.1 хувийг тусгай зориулалтын болон эм боох материал, 932.3 сая төгрөг буюу 7.8 хувийг бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэл, барилгын засвар, хүнсний материал, 460.2 сая төгрөг буюу 3.7 хувийг сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун, 298.8 сая төгрөг буюу 2.4 хувийг байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой бараа материал тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад бараа материалын данстай холбоотой 534.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Асруулагчийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 122.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 40.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн; /АНҮТ/
- Худалдан авалтын гэрээний дүнгээс илүү худалдан авалт хийсэн, худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь зөрүүтэй зэрэг нийт 43.9 сая төгрөг; /АНҮТ 40.2 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ХХҮГ 3.7 сая төгрөг/
- Хөрөнгийн тооллогын комисс нь 182.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй. тооллогыг чанаргүй зохион байгуулсан /ХХҮЕГ-144.6 сая, ХУД ХХҮГ 6.4 сая төгрөг, СХД ХХҮГ 8.5 сая төгрөг, СЗСҮТ-4.0 сая, ДГА-ийн ХГБХХГ 13.6 сая төгрөг, СХД-ийн ХГБХХХ 5.7 сая төгрөг/
- Биет бус хөрөнгийн шинж чанартай 3.8 сая төгрөгийн үнэ бүхий программ, хангамжийг бараа материалын дансанд бүртгэсэн. /Сүхбаатар дүүргийн НДГ 3.8 сая төгрөг/
- Тооцоо судалгаанд үндэслэхгүйгээр 118.0 сая төгрөгийн бараа материалыг их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн; /ХУД-ийн ХГБХХХ 11.6 сая төгрөг, СБД-ийн ХГБХХХ 10.8 сая төгрөг, ЧД-ийн ХГБХХХ 3.5 сая төгрөг, ХБХСЗХТ-92.1 сая/
- Ашиглалтын шаардлага хангахгүй 23.6 сая төгрөгийн хөрөнгүүдийг бараа материалын дансанд бүртгэсэн. /ХХХСХТ/

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 78,396.4 сая төгрөг болж, өмнөх оноос 9,617.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	68,778.6	78,396.4	9,617.8
Дүн	68,778.6	78,396.4	9,617.8

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 18 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр хуримтлуулан бүртгэсэн нийт 77,506.5 сая төгрөгийн дуусаагүй ажил, ХЭДС-ийн Капитал банкнаас авах авлагад авсан борлуулах зориулалттай 36.5 сая төгрөгийн авто машин, ГБХНХЯ-ны дансанд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд эмнэлгийн зориулалтай барилга байгууламж барих ажлын 217.0 сая төгрөгийн зураг төсөл, Залуучуудын хөгжлийн төвийн барилгын /Налайх дүүрэг/ гүүрний зориулалтай барилга, байгууламж барих ажлын 636.4 сая төгрөгийн зураг, төсөл тус тус бүртгэлтэй байна.

Тайлант онд бусад эргэлтийн хөрөнгө нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 34 төсөл, арга хэмжээний санхүүжилт 30,237.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Нөхөн сэргээх, хүүхэд хөгжил, сургалтын төвийн барилгын 4,569.7 сая төгрөг, Спорт заал бүхий “Иргэдийн хөгжлийн төв”-ийн барилгын 3,401.9 сая төгрөг, Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн барилгын /Сэлэнгэ, Баруунбүрэн/ 2,033.0 сая төгрөг, Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төвийн их засвар 1,216.0 сая төгрөг, ХАБЭМТ-ийн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний зөөврийн багаж тоног төхөөрөмж 346.9 сая төгрөг, лабораторийн шинжилгээний багаж тоног төхөөрөмж 899.0 сая төгрөг, дүрс оношилгоо лабораторийн тоног төхөөрөмж 967.6 сая төгрөг, яаралтай тусламж сэргээн засан эмчилгээний багаж тоног төхөөрөмж ариутгал угаалгын багаж хэрэгслийн 585.3 сая төгрөг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын серверийн 728.6 сая төгрөг, салбарын бусад тоног төхөөрөмжийн 8,700.4 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ашиглагч байгууллагуудад шилжүүлж бүртгэж, нийт 9,617.8 сая төгрөгөөр өссөн байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 225,355.6 сая төгрөг болж, өмнөх оноос 22,737.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	186,753.5	202,793.7	16,040.2
Биет бус хөрөнгө	15,864.2	22,561.9	6,697.7
Дүн	202,617.7	225,355.6	22,737.9

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,737.9 сая төгрөгөөр өссөн нь ГБХНХС-ын 2025 оны “Хөрөнгийн хуваарилалт батлах тухай” А/131 тоот тушаалын дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ зэрэг төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн нийт 12,227.8 сая төгрөгийн хөрөнгө, харьяа байгууллагуудын их засварын хөрөнгө оруулалт болох 1,216.0 сая төгрөгийн худалдан авалттай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө худалдан авсан 4,889.0 сая төгрөг, балансаас баланст болон бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн хүлээн авсан 37,713.3 сая төгрөг, хандиваар үнэ төлбөргүй авсан 2,985.8 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 533.4 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг акталж данснаас хассан 6,995.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 13,813.8 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 381.0 сая төгрөгөөр тус тус хасагдаж, 17,585.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн үндсэн хөрөнгийн данстай холбоотой 22,516.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Хөрөнгийн тооллогын комисс нь тооллого хийсэн тайланд үндсэн хөрөнгийн мөнгөн дүнг санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй тусгасан, хөрөнгийн тооллогыг чанаргүй зохион байгуулсан 14,814.9 сая төгрөг; /ХХҮЕГ 4,130.3 сая төгрөг, НД-ийн ХХҮГ 4.4 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 10,680.2 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 150.6 сая төгрөгийн хөрөнгийг нотлох баримтгүй акталж устгасан; /БЗД ХХҮГ 148.0 сая төгрөг, Нийслэлийн ХХҮГ 2.6 сая төгрөг/
- Байгууллагын эзэмшилд байгаа 4.0 сая төгрөгийн газрыг үндсэн хөрөнгөнд бүртгээгүй, тавилга эд хогшлын ангилалд 13.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэсэн зэрэг хөрөнгийг ангиллыг буруу бүртгэсэн, нийт 17.5 сая төгрөг; /БЗД ХХҮГ 4.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн ХХҮГ 13.5 сая төгрөг/
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5,244.7 сая төгрөгийн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлэх арга хэмжээ аваагүй; /ОУХНЦ 1,848.4 сая төгрөг, ХГБХХЕГ 1,228.9 сая төгрөг, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв 210.7 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 141.1 сая төгрөг, Завхан аймгийн ХГБХХГ 99.7 сая төгрөг, Дорнод аймгийн ХГБХХГ 64.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ХГБХХГ 13.6 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХГБХХГ 8.6 сая төгрөг, БНСУ дахь ХНХҮТ 19.7 сая төгрөг, Дундговь аймгийн НДГ 56.3 сая төгрөг, Төв аймгийн НДГ 32.0 сая төгрөг, ХБХСЗТ 1,520.9 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг алдаатай тооцсон, дээд байгууллагаас шилжиж ирсэн 54.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих журам, стандартын дагуу бүртгээгүй, хөрөнгө оруулалтын төсөв батлуулаагүй байхад 79.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн; /Сонгинохайрхан дүүргийн НДГ 25.0 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн НДГ 4.6 сая төгрөг, Хан-Уул дүүргийн НДГ 0.1 сая төгрөг, Орхон аймгийн НДГ 25.0 сая төгрөг, ХБИХЭДТ 79.9 сая төгрөг/
- Технологийн хоцрогдолд орсон, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй 4.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэлтэй; /ХХХСХТ/
- ТӨБЗГ-ын 2020 оны А/1/1981 дугаар зөвшөөрлийн дагуу 21.7 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2022 онд холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн боловч 2023-2024 онуудын жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүйгээс тус хөрөнгөнд хуримтлагдсан элэгдэл тооцсон. /ХБХХЕГ/

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 32,039.0 сая төгрөг болж, өмнөх оноос 510.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,914.8	21,561.3	2,646.5
Өглөг	1,460.9	10,070.8	8,609.9
Урьдчилж орсон орлого	17,453.9	11,185.5	(6,268.4)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,614.1	10,477.7	(2,136.4)
Урт хугацаат зээл	12,614.1	10,477.7	(2,136.4)
Нийт дүн	31,528.9	32,039.0	510.1

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 510.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ХЭДС-ийн жижиг зээлийн эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдлийн 10,070.8 сая төгрөг буюу 31.4 хувийг байгууллагад төлөх болон хувь хүнд төлөх өглөг, 11,185.5 сая төгрөг буюу 35.0 хувийг урьдчилж орсон орлого, 10,477.7 сая төгрөг буюу 32.7 хувийг урт хугацаат зээл, ажилчидтай холбоотой өглөг болон бараа үйлчилгээний зардлын өглөг 305.0 сая төгрөг буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд ХЭДС-ийн гадаадын иргэний ажлын байрны төлбөрийн 11,082.5 сая төгрөг, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн протез ортопедийн төлбөрийн 26.9 сая төгрөг, Олон улсын хүүхдийн Найрамдал төвийн төлбөртэй үйлчилгээний урьдчилгаа 76.0 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ХЭДС-ийн 10,477.7 сая төгрөгийн Дэлхийн банкнаас авсан жижиг зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад байгууллагуудад өр төлбөрийн данстай холбоотой 275.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Тайлант онд өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, шинээр өр төлбөр үүсгэсэн нийт 259.4 сая төгрөг; /Баянхонгор аймгийн ХЭДС 30.8 сая төгрөг, Төв аймгийн ХЭДС 8.6 сая төгрөг, Орхон аймгийн ХЭДС 150.1 сая төгрөг, Өмнөговь аймгийн ХХҮГ 50.1 сая төгрөг, Өнөр бүл хүүхдийн төв 4.5 сая төгрөг, СБД НДГ 15.3 сая төгрөг/
- Төв аймгийн ХХҮГ нь 11.1 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Нийслэлийн ХГБХХХ татан буугдаж байгаатай холбоотойгоор Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусгаагүй ХХОАТ-ын 4.3 сая төгрөгийн олон жил болсон өр төлбөрийг тайлант оны зардлаас төлсөн;
- Чингэлтэй дүүргийн НДГ нь ЦХТАОСТ-ын өглөгийг 0.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 866,858.4 сая төгрөг болж, өмнөх оноос 218,979.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	62,889.7	62,185.2	(704.5)
Хуримтлагдсан үр дүн	544,344.0	765,729.7	221,385.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,645.3	38,943.5	(1,701.8)
Дүн	647,879.0	866,858.4	218,979.4

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 218,979.4 сая төгрөгөөр өссөн нь засгийн газрын оруулсан капитал болон хуримтлагдсан үр дүнгээс голлон шалтгаалжээ.

Засгийн газрын оруулсан капиталын үлдэгдэл 62,185.2 сая төгрөг болж, 704.5 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолоор Нийслэлийн хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын чиг үүргийг төрийн захиргааны болон харьяа байгууллагуудад шилжүүлэн татан буулгаж, үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас программ хангамжийн судалгаа авахад 8,974.2 сая төгрөгийн программ хангамжийг ашиглаж байна. Харьяа байгууллагууд нь санхүүгийн “Аксplorер”, “Acolous”, “Sicos” программуудыг ашигладаг бөгөөд тайлант онд нэмэлт хөгжүүлэлтэд 2,785.0 сая төгрөгийн зардлыг урсгал зардлаас зарцуулжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасны дагуу тус ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-д заасны дагуу ГБХНХС-ын төсвийн багцын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,376,458.8 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас санхүүжих 3,035.1 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 73,893.5 сая төгрөг, дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс 42,900.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 51,896.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр, нийт зардлыг 6,548,183.5 сая төгрөгөөр тооцон боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01/1950 дугаар албан бичгээр 2025 оны төсвийн төслийн саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

ТЕЗ-ийн боловсруулсан төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 775,250.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1,762.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,864.3 сая төгрөгөөр, нормативд зардлыг 1,048.2 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 3,404.0 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,568.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 285,237.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,649.2 сая төгрөгөөр, төрийн өмчит байгууллагад олгох татаасыг 573,028.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 52,101.4 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийг 268,363.8 сая төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,042.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, урсгал зардлыг 4,536,689.9 сая төгрөгөөр УИХ-аас баталжээ.

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхэд нийт 4,382,838.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,035.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 58,992.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 6,126.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 47,797.2 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 4,536,689.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

УИХ-аас 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, тайлант оны батлагдсан төсвийг 42,041.3 сая төгрөгөөр бууруулж, 4,494,648.6 сая төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэлээр тайлант онд 233,559.6 сая төгрөгөөр батлагдсан төсвийг дутуу зарцуулсан болон төсөвт 149,917.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлснээс үзэхэд төсвийг бодитой төлөвлөх шаардлагатай байгааг харуулж байна.

3.6.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 68,277.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 214,796.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 146,518.6 сая төгрөгөөр буюу 3.0 дахин давуулан биелүүлжээ. Тайлант онд 306.9 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт №10. Улсын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Төвлөрүүлэх нийт орлого	3,035.1	3,634.5	599.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	3,035.1	3,634.5	599.4
Харьяа төсөвт байгууллагын орлого	65,242.6	211,161.8	145,919.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,742.6	199,523.3	135,780.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500.0	11,638.5	10,138.5
Нийт дүн	68,277.7	214,796.3	146,518.6

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.3 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,196,209.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, эрүүл мэндийн даатгалын сангаас 3,634.5 сая төгрөгөөр санхүүжиж, үйл ажиллагааны орлогоос 211,161.8 сая төгрөг, нийт 4,411,006.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,261,089.0 сая төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын хөтөлбөрийг 4,594.6 сая төгрөг, нийгмийн халамжийн хөтөлбөрийг 105,022.0 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг 83,191.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг 13,990.5 сая төгрөгөөр, хүүхдийн хөгжил хамгааллын

хөтөлбөрийг 23,844.4 сая төгрөг, хөдөлмөр нийгмийн хамгааллын бодлого удирдлагын хөтөлбөрийг 2,917.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
Нийт дүн			4,494,648.6	4,261,089.0	233,559.6	94.8
1	71901	Нийгмийн даатгал	1,566,523.6	1,561,929.0	4,594.6	95.9
2	71902	Нийгмийн халамж	2,592,889.4	2,487,867.4	105,022.0	45.4
3	72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	152,498.6	69,307.6	83,191.0	69.7
4	72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил	46,161.5	32,171.0	13,990.5	79.1
5	72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	114,236.2	90,391.8	23,844.4	86.9
6	72208	Хөдөлмөр нийгмийн хамгааллын бодлого удирдлага	22,339.3	19,422.2	2,917.1	94.8

Эх сурвалж: ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 7 төрлийн судалгааг авч үр дүнг нэгтгэн, тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авсан.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад төрийн захиргааны 3,294, төрийн үйлчилгээний 2,106, НДҮЗ-ийн ажлын албаны 15, нийт 5,415 орон тооны баталсныг төсвийн тодотголоор 4,874 болгон 9.0 хувь буюу 541 орон тоогоор бууруулах арга хэмжээг авчээ.

Төсвийн тодотголд салбарын хэмжээнд 541 орон тоо буюу 12,500.0 сая төгрөгийн цалин, шимтгэлийн зардлыг бууруулахдаа дараах байдлаар тооцсон байна. Үүнд:

- Төрийн захиргааны орон тоог 12.3 хувиар буюу 404 орон тоо;
- Төрийн үйлчилгээний орон тоог 6.5 хувиар буюу 136 орон тоо;
- НДҮЗ-ийн ажлын албаны орон тоог 6.7 хувиар буюу 1 орон тоогоор тус тус бууруулсан байна.

НДЕГ-ын харьяа байгууллагуудад 34 орон тоо /102.0 сая төгрөг/, ХГБХХЕГ-ын харьяа байгууллагад 36 орон тоо /118.3 сая төгрөг/, ХХҮЕГ-ын харьяа байгууллагуудад 54 орон тоо /217.0 сая төгрөг/, ГБХНХЯ 2 орон тоо /12.9 сая төгрөг/, нийт 126.0 орон тоог цомхотгож, холбогдох хууль, тогтоомжийн дагуу 450.2 сая төгрөгийн тэтгэмжийг олгожээ. Салбарын хэмжээнд сул байгаа 429 орон тоонд томилгоо хийгдээгүй байна.

2. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 24,703.1 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 23,573.8 сая төгрөгийг олгож, батлагдсан төсвийг 1,129.3 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ. Тухайлбал:

- ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны А/74 дүгээр тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 25.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр баталж, тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээнд өөрчлөлт ороогүй;
- НДЕГ-ын харьяа байгууллагууд: НДЕГ-ын даргын “Албан хаагчдын унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2025 оны А/307 дугаар тушаалаар алба хаагчдын ажлын нөхөх төлбөрийн хэмжээг нэг өдөрт 35.0 мянган төгрөгөөр (нэг өдрийн хоолны мөнгийг 34.0 мянган төгрөг, унааны төлбөрийг 1.0 мянган төгрөгөөр) баталсан;

- ХХҮЕГ-ын харьяа байгууллагуудын өдрийн хоол унааны хөнгөлөлтийн зардлыг 15.0-34.0 мянган төгрөгөөр баталсан; Тухайлбал: Баянхонгор аймгийн ХХҮГ нь аймгийн мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 34.0 мянган төгрөг, сумын мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 20.0 мянган төгрөг, Өмнөговь аймгийн ХХҮГ нь аймгийн мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 34.0 мянган төгрөг, сумын мэргэжилтнүүдийн өдрийн хоолны зардлыг 20.0 мянган төгрөг, төрийн үйлчилгээний ажилтнуудын өдрийн хоолны зардлыг 17.0 мянган төгрөг, Булган аймгийн ХХҮГ нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар албан хаагчдын өдрийн хоолны зардлыг 15.0 мянган төгрөгөөр тогтоосныг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Б/128 дугаар тушаалаар 30.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.
- ХГБХХЕГ-ын харьяа байгууллагуудын өдрийн унаа, хоолны хөнгөлөлтийн зардлыг нийслэлд 35.0 мянган төгрөгөөр, орон нутгийн албан хаагчдын хоол унааны зардал 3 аймаг 20.0 мянган төгрөг, 16 аймаг 15.0 мянган төгрөг, 1 аймаг 12.0 мянган төгрөг, аймаг 8.0 мянган төгрөгөөр тус тус баталсан;
- ХБХХЕГ-ын харьяа байгууллагуудын өдрийн унаа, хоолны хөнгөлөлтийн зардлыг 12.0-30.0 мянган төгрөгөөр баталсан; /ХБХХЭДТ 30.0 мянган төгрөг, ХБХСЗТ 12.0 мянган төгрөг/
- ХАБЭМТ нь даргын 2025 оны Б/06 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардалд 23.0 мянга, унааны зардалд 2.0 мянган төгрөгөөр баталсан;
- ХНХССХ нь захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны Б/01 тушаалаар ажилтны 1 өдрийн хоолны хөнгөлөлтийг 29.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Дээрх судалгаанаас үзэхэд унаа, хоолны хөнгөлөлтийг салбарын хэмжээнд харилцах адилгүй тогтоож, Улаанбаатар хотод дунджаар унааны зардлыг 2.0 мянган төгрөг, хоолны зардлыг 23.0 мянган төгрөгөөр, орон нутагт унаа хоолны зардлыг дунджаар 12.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

3. Гадаад томилолтын зардалд нийт 149.9 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 149.9 сая төгрөгийг тайлагнасан.
 - Зардлын эдийн засгийн ангилал зөрчин 26.9 сая төгрөгийг гадаадад томилолтоор ажиллахад зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 10.9 сая төгрөгийн томилолтын зардал олгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. /ГБХНХ 21.3 сая төгрөг, ХГБХХЕГ 16.5 сая төгрөг, ХХҮЕГ 18.1 сая төгрөг/
4. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,056.8 сая төгрөгийг баталснаас тайлант хугацаанд 2,256.5 сая төгрөгийг зарцуулжээ. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь тайлант онд 106 удаагийн сургалт зохион байгуулан нийт 811 хүн хамруулахаар төлөвлөж, 106 сургалтыг бүрэн зохион байгуулсан байна.
5. Салбарын үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлаг видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлахад нийт 369.4 сая төгрөгийг /ХГБХХЕГ 168.8 сая төгрөг, ГБХНХЯ 200.6 сая төгрөг/ төлөвлөж, гүйцэтгэлээр 58 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, 347.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.
 - ГБХНХЯ-ны салбарын үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлаг видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлах ажлын зардал 192.5 сая төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулалгүй батлагдсан төсөвт өртгийг хуваан 29 хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.
6. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тайлант онд 44.0 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гарсан байна. Үүнд:
 - ХБХХЕГ-ын харьяа 2 байгууллагаас төрд учирсан хохирлыг барагдуулах зардалд нийт 7.2 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байгууллагын төсвөөс төлж авлага үүсгээгүйг аудитын явцад залруулга хийлгэсэн;
 - ХХҮЕГ нь тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой 36.8 сая төгрөгийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй цалин, нэмэгдэл хөлс олгох зардлаас зарцуулсан.

3.6.4 Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл:

ТЕЗ-ийн 2025 оны бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 45 төсөл, арга хэмжээний нийт 48,728.1 сая төгрөгийг хөрөнгийн санхүүжилтээр, 2,937.7 сая төгрөгийг урсгал санхүүжилтээр бэлтгэхээр тус тус тусгажээ.

Гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын санхүүжилтээс өмнөх оноос шилжсэн 40 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 38,459.6 сая төгрөгийг олгож, урсгал зардлын санхүүжилтээс 85.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг харьцуулалтаар аргаар, 12,470.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад худалдан авалттай холбоотой 5,361.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Нэг төрлийн ижил бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийг хуваан 693.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн; /ГБХНХЯ 223.1 сая төгрөг, ХГБХХЕГ 149.2 сая төгрөг, Төв аймгийн ХГБХХГ 54.6 сая төгрөг, ХХХҮТХБ 40.3 сая төгрөг, ХБХСЗХТ 263.9 сая төгрөг, ХХХСХТ 62.0 сая төгрөг/
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны ажлын хүрээнд 938.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн “Аргун студио” ХХК-тай “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрд хүртээмжтэй хүргэх” ажил гүйцэтгэх гэрээг 535.3 сая төгрөгөөр байгуулж, 997,000 ширхэг гар утсанд татан суулгах QR бүхий, зурагтай наадаг стикерийн зардалд 224.3 сая төгрөг, “Гэр бүлийн виртуал зөвлөх” үйлчилгээг 3 жилийн хугацаатай ашиглах зардалд 310.9 сая төгрөгийг зарцуулсан; /ХГБХХЕГ/
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 1,238.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн; /ОУХНЦ 1,143.2 сая төгрөг, ГБХНХЯ 95.2 сая төгрөг/
- Нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан 5 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү үнийн дүнтэй худалдан авалт хийж 107.0 сая төгрөгийг илүү зарцуулсан. /ОУХНЦ/
- Төсвийн хөрөнгөөр 237.0 сая төгрөгийн бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй; /Чингэлтэй дүүргийн ХГБХХХ 118.2 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ХГБХХХ 113.1 сая төгрөг, Булган аймгийн ХГБХХГ 5.7 сая төгрөг/
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn-д ил тодоор мэдээлээгүй; /БГД-ийн НДГ/
- НДЕГ нь 2,900.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн тайлагнаагүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй төлөвлөгөөнд батлагдаагүй худалдан авалт хийсэн, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 16 дугаар зүйлд заалтуудыг зөрчиж тендерийн баримт бичгийг боловсруулсан. /НХСан 1,725.4 сая төгрөг/

3.6.5 Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэрэгжилт:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 21 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 12. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Код	Д/д	Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
31	31.1	71901 Нийгмийн даатгал			
		31.1.1.1	Албан журмын даатгуулагчийн ажиллагсдын тоонд эзлэх хувь	93.4	96.3
		31.1.1.2	Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь	61.7	54.5
		31.1.1.3	Малчдын сайн дурын даатгалд хамрагдалт	24.0	24.0
	31.2	71902 Нийгмийн халамж			
		31.2.1.1	Нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцаа	85.0	85.8
		31.2.1.2	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн түвшин	50.0	83.3
	31.3	71903 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого удирдлага			
		31.3.1.1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нийгмийн хамгааллын салбарын бодлогын хэрэгжилтийн биелэлт	85.0	66.2

	31.3.1.2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөдөлмөрийн салбарын бодлогын хэрэгжилтийн тайлан	85.0	64.0
31.4	72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих			
	31.4.1.1	Бага цалинтай ажиллагсдын хувь	11.0	8.4
	31.4.2.1	Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргаан	650.0	978.0
	31.4.3.1	Ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол	380.0	809.0
	31.4.4.1	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн	14,564	18,835
	31.4.4.2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн	35,633	22,884
31.5	72206 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал			
	31.5.1.1	Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэнээс биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын стандарт ангиллын дагуу үнэлгээ хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн	5	9.3
	31.5.1.2	Төрөлхийн болон алдагдсан чадварыг нь сэргээсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн	16	14
	31.5.1.3	Урт хугацааны идэвхтэй давтан хяналтад хамрагддаг хүүхэд	95	83
	31.5.2.1	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн	10,500	-
	31.5.3.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, хүүхэд зэрэг хүн амын бүлэгт ээлтэй, хүртээмжтэй болгосон иргэний барилга байгууламж	13	13
	31.5.3.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн түвшин	40	40
31.6	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал			
	31.6.1.1	Нийт гэр бүлд гэрлэлт цуцлалтын эзлэх хувь	2.2 буурна	2.1
	31.6.2.1	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь	4.95	1.3
	31.6.2.2	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь	70	7.6

Эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ирүүлсэн ХШҮ-ий тайлан.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дараах 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээний биелэлт хангалтгүй байна. Үүнд:

- **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага:** Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Нийгмийн хамгааллын чиглэлээр туссан зорилт, арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 66.2 хувийн биелэлттэй гэсэн үнэлгээ өгсөн.
- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал:** Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд 2025-2026 оны хичээлийн жилд боловсролын үйлчилгээнд нийт 9,890 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж байгаа бөгөөд үүнээс их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд 980 иргэн хамрагдаж байна. Өмнөх 2024 онд 1,090 хөгжлийн бэрхшээлтэй иргэн их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд суралцаж байсан.
- **Хүүхдийн хөгжил хамгаалал:** Монгол Улсад оршин суугаа 0-18 нас хүртэлх хүүхдийн тоо 2025 оны байдлаар 1,261,317 байна. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 2025 оны байдлаар жилийн эцсийн байдлаар 96,751 хүүхэд хамрагдсан нь нийт хүүхдийн 7.6 хувийг эзэлж байна.

ГБХНХЯ-ы Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгааныг:

- “Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийн Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувийг тайлант онд 70 хувьд хүргэхээр төлөвлөсөн нь төлөвлөлтийн хувьд алдаатай, үнэлэх боломжгүй;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн “Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийн хүрэх түвшин, суурь түвшний тоо мэдээллийг сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа нийт суралцагчийн тоогоор баталснаас шалтгаалан тайлант онд их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд сурч байгаа 980 суралцагчийн тоо мэдээллийг суурь түвшин, хүрэх түвшинд харьцуулан үнэлэх боломжгүй” гэж дүгнэсэн байна.

ҮАГ-н Нийцлийн аудитын газраас “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланд:

- ГБХНХЯ нь хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэмжих нэгж уялдаагүй 2 арга хэмжээ, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус 1 арга хэмжээг төлөвлөсөн;
- Хүний хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд “Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ” ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох “Хүүхдийн эрхийн индекс батлагдаагүй;
- “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана” арга хэмжээнүүдийн зорилтот түвшинг оновчтой тодорхойлоогүйгээс зорилтот үр дүнд хүрээгүй байна” гэж тус тус тусгажээ.

3.6.6 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын болон Засаг даргын нөөц сангаас 16,152.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 13,640.0 сая төгрөг, төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ-ын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 26.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,335.9 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 1,068.2 сая төгрөгийн хандив тусламж, нийт 33,222.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн, 31,796.7 сая төгрөгийг зарцуулж, 1,426.0 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой 22.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр бэлтгэсэн 15.0 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн. /НДЕГ/
- Нэмэлт санхүүжилтийн зардлаас 7.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авалт хийж, шууд зардалд тайлагнасан. /Орхон аймгийн НДГ/

3.6.7 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

ГБХГХС-ын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын 2 эх үүсвэрээр 3 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэл 95.2 хувьтай байна.

Хүснэгт 12. Төсөл хөтөлбөрийн биелэлт

/сая төгрөгөөр/

№	Санхүүжүүлэгч байгууллагын нэр	Төслийн нэр	Хугацаа	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Хэрэгжилт хувиар
1	Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциаци	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	2020 2025	3,195.8	3,161.2	98.9
2	Азийн хөгжлийн банк	Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл	2021 2025	4,238.2	3,829.6	90.0
3		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл	2018 2025	4,235.9	4,095.2	96.6
Нийт дүн				11,669.0	11,086.0	95.2

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ГБХНХС-н эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд хийсэн ТЕЗ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

ТЕЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах болон нягтлан бодох бүртгэл, мөнгөн хөрөнгө, дотоод хяналт, хөрөнгө оруулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал, Д.Номингуа нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 01/1134 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,872,707.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 38,727.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 99.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- ХХҮЕГ-ын харьяа Орхон аймгийн ХХҮГ нь Ахмадын сангаас ахмадуудын контент бүтээхэд 0.4 сая төгрөг;
- ГБХНХЯ нь 7 аж ахуйн нэгжээс 82.2 сая төгрөгийн бэлэг, дурсгалын зүйлс бэлтгэсэн, дээрх үйл ажиллагааны урилга хэвлүүлэхэд 4.3 сая төгрөг, мэндчилгээ хэвлүүлэхэд 2.2 сая төгрөг, спортын арга хэмжээнд зориулж 1.0 сая төгрөг, нийт 89.7 сая төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан;
- Говьсүмбэр аймгийн ХЭДС нь видео контент хийлгэхэд 3.5 сая төгрөг, НХС нь 6.2 сая төгрөгийг контент бэлтгэх ажилд тус тус зарцуулсан.

4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад нийцлийн аудиттай холбоотой нийт 252,952.4 сая төгрөгийн 130 зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 20,971.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 43 албан шаардлага, 215,878.4 сая төгрөгийн 4 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 16,100.8 сая төгрөгийн 80 зөвлөмж хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 242,756.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс төсвийн төвлөрүүлэн захирагч нарт 19,452.9 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 215,810.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 7,193.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна. Тухайлбал:

- Цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүнтэй 7,412.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй. /Өвөрхангай аймгийн ХХҮГ 210.6 сая төгрөг, Баянхонгор аймгийн ХХҮГ 97.0 сая, БНСУ дахь ХНХҮТ 78.0 сая төгрөг, ХХҮЕГ 37.5 сая төгрөг, ОУХНЦ 343.7 сая төгрөг, Хүүхдийн түргэн тусламжийн 108 261.1 сая төгрөг, ХХХҮЗТХБ 399.2 сая төгрөг, Дорнод ХГБХХГ 258.4 сая төгрөг, Өмнөговь аймгийн ГБХХГ 338.9 сая төгрөг, Увс ГБХЗХЗ 3,714.7 сая төгрөг, НД ГБХХХ 57.4 сая төгрөг, БЗД ГБХХХ 1,342.4 сая төгрөг, БХД ГБХЗХХ 66.1 сая төгрөг, НДЕГ 206.9 сая төгрөг, СХД НДГ 0.8 сая төгрөг/
- Цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүнтэй 11,038.7 сая төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй; /ХГБХХЕГ-аппарат 10,667.1 сая төгрөг, Нийслэлийн ГБХЗХГ 371.6 сая төгрөг/
- Шилэн дансны цахим хуудсанд 84.9 сая төгрөгийн тушаал шийдвэр, нотлох баримтыг хавсаргаагүй; /Дундговь аймгийн ХГБХХГ 84.9 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХЭДС/
- Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих зарим мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон, зөрчлийг давтан гаргасан 224,220.2 сая төгрөг; /Дархан-Уул аймгийн ХБХХТөв 3,249.9 сая төгрөг, ХБИХЭДТ 1,394.4 сая төгрөг, Дорнод аймгийн ХБХХТөв 41.5 сая төгрөг, ХБХХЕГ 5.9 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ХЭДС 3,964.7 сая төгрөг, НХСан 215,466.3 сая төгрөг, ГБХНХЯ 97.5 сая төгрөг/

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна.", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ." Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.", 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж, хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт болон журамтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

1. ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлогыг төсвийн тодотголоор бууруулж баталсан, зарим орлогыг төлөвлөөгүй зэргээс шалтгаалан жил бүр орлогын төлөвлөгөөний батлагдсан дүнгээс давсан орлогыг өөрийн үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Тухайлбал: 2023 онд 61.1 сая төгрөг, 2024 онд 110.7 сая төгрөг, 2025 онд 146.5 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 22 дугаар зүйлийн 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны бодит гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байх.

2. БЗД, СХД-ийн орон нутгийн төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮДТ-ээс гадна ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй дээрх 2 дүүргийн ЖДҮДТ-ийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж байна. Үүнд: Тус төвүүдийн санхүүгийн тайланд нийт 4.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө (БЗД- 4.8 сая төгрөг, СХД-0.01 сая төгрөг), БЗД-ийн 282.1 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө (хуримтлагдсан элэгдэл 61.0 сая төгрөг хассан), 80.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй (БЗД-ийн ЖДҮДТ-15.9 сая төгрөг, СХД ЖДҮДТ-64.8 сая төгрөг) байна.

Эдгээр хөрөнгүүдийг холбогдох эрх бүхий байгууллагуудад асуудлыг тавьж шийдвэрлээгүй, бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас цаашид хөрөнгийн үнэ цэн буурч, чанар байдал алдагдаж, үрэгдэж, шамшигдах эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5. "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.11. "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагаа нь бүрэн зогссон дээрх байгууллагуудыг татан буулгах, саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах.

4.4.3 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 73,519.8 сая төгрөгийн 352 зөрчил илэрснээс, 295.4 сая төгрөгийн 54 төлбөрийн акт, 22,660.6 сая төгрөгийн 103 албан шаардлага, хариуцлага тооцох 22,892.3 сая төгрөгийн 7 албан шаардлага, 39,373.0 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 92.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт			Биелэлт		Зөрүү		
	төрөл	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт		55	306.6	54	295.4	1	11.3	96.3
Албан шаардлага	Зөрчил арилгах	109	32,605.6	103	25,660.6	6	6,944.9	78.7
	Хариуцлага тооцох	7	22,892.3	7	22,892.3	0	0.0	100.0
Зөвлөмж		188	40,607.6	181	39,373.0	7	1,234.6	96.9
Нийт дүн		352	73,519.8	338	55,675.2	14	8,190.8	92.9

ТЕЗ-ийн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ГБХНХЯ-ы Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төрд учруулсан хохирлыг барагдуулах, хууль бус шийдвэр гаргасан 43 албан тушаалтнаар нөхөн төлүүлэх 432.7 сая төгрөгийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх талаар Төрийн албан зөвлөлтэй хамтран ажилласан байна. Тайлант онд Төрийн албан зөвлөлд 257.9 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг барагдуулах, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлснээс Завхан аймгийн НДГ-ын 0.6 сая төгрөг, ЧД-ийн НДГ-ын 3.8 сая төгрөг, ХБХХЕГ-ын 31.1 сая төгрөг, ХНХСҮТ-ийн 25.3 сая төгрөг, нийт 60.8 сая төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, БНД-ийн ХХҮХ-ийн 33.0 сая төгрөгийн хариуцагч нас барсан, ХХҮЕГ-ын 72.0 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- ХГБХХЕГ нь өмнөх оны аудитаар өгөгдсөн нэр бүхий 15 ажилтанд нийт 11.2 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон төлбөрийн актыг төлж барагдуулаагүй, 1 аж ахуйн нэгжид протезын үйлдвэрийг дэмжих зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй хугацаа хэтэрсэн зөрчилд өгсөн албан шаардлага хэрэгжээгүй;
- ХЭДС-ийн 20,837.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 5.8 хувь буюу 1,180.1 сая төгрөг барагдаж, нийт 19,088.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй;

- Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онд орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн өмнөх оны үлдэгдэл 12,863.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлээс тайлант онд 36.0 хувь буюу 4,607.3 сая төгрөг барагдаж, 8,256.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тайлант онд тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч бүрэн барагдаагүй зэрэг ХЭДС-ийн биелэлт хангалтгүй зөрчлүүдэд зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.
- ГБХНХЯ-ы анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 98.7 сая төгрөгийг бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн зөрчилд хүргүүлсэн албан шаардлагын биелэлт 63.5 хувийн биелэлттэй байна. Тайлант онд хариуцсан албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн тул давтан гарсан зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.4 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар дахин авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 оноос хэрэгжиж байгаа Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын “Усан спортын цогцолборын барилга”-ын ажлын гүйцэтгэлд горим сорил хэрэгжүүлэх;
- ТТЗ-ийн хөрөнгөд бүртгэлтэй байгаа болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн программ хангамжийн худалдан авах ажиллагаа, түүний ашиглалтад горим сорил хэрэгжүүлэх. Үүнд: НДЕГ-ын даргын 2025 оны А/314 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, 12 дугаар сарын 15-ны өдөр “Ай Ти Зон” ХХК-ас системийн эх кодыг хүлээн авч, 2,759.9 сая төгрөгийн өртөг бүхий программ, хангамжийг НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн байна. Тайлант онд системийн хөгжүүлэлтийн хүрээнд нийт 2,707.8 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь системийн өртгийн үндэслэлийг мэдээллийн технологийн аудитын хүрээнд нарийвчлан шалгаж, зарцуулсан зардал нь бодит гүйцэтгэл, техникийн үр дүнтэй уялдсан эсэхийг мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн шинжээч оролцуулан гүйцэтгэлийн аудитаар хамруулан үзэх нь зүйтэй байна
- ХБХХЕГ-ын харьяа 7 /Архангай, Ховд, Дархан, Дорнод, Хөвсгөл, Дундговь, Өмнөговь аймгийн ХБХХГ/ байгууллага нь улсын төсөвт үйлдвэрийн газрын статустай боловч санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар гаргаж байгаа нь байгууллагын статустай нийцэхгүй байгаад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 305,635.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 206 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 143,229.4 сая төгрөгийн 453 зөрчил² илэрснээс, 460.4 сая төгрөгийн 62 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123.231.0 сая төгрөгийн 171 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 521.3 сая төгрөгийн 5 хариуцлага тооцох албан шаардлага, 19,016.6 сая төгрөгийн 215 зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 143,229.4 сая төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 104,502.4 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 164 төсвийн захирагч нарын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 121 байгууллагад дүгнэлт гаргаж, 43 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 87 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, “Хязгаарлалттай” 34 (ТТЗ-3, ТШЗ-30, ЗГТС-1) дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 139,011.2 сая төгрөгийн 451 зөрчил³ илэрснээс, 460.4 сая төгрөгийн 62 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123,213.0 сая төгрөгийн 170 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 521.0 сая төгрөгийн 5 хариуцлага тооцох албан шаардлага, 14,798.3 сая төгрөгийн 214 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:

Аудитаар 4,218.2 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар 1 албан шаардлага, 4,218.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.2.1. Албан шаардлага:

ГБХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 444,646.6 сая төгрөгийн 659 алдаа, зөрчил илэрснээс залруулагдаагүй нийт 139,011.2 сая төгрөгийн 451 зөрчил илэрснээс, 460.4 сая төгрөгийн 62 төлбөрийн акт тогтоож, 123,231.0 сая төгрөгийн 170 албан шаардлага, 521.3 сая төгрөгийн 5 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 14,798.4 сая төгрөгийн 214 зөвлөмж өгсөн. ТЕЗ-ын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар аудитаар илэрсэн зөрчил нь өмнөх оноос 1.4 хувиар нэмэгдсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагад илэрсэн зөрчлийг бууруулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав.

Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж тайлант онд ашиглалтад оруулсан 2,954.0 сая төгрөгийн үнэ бүхий Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-өндөр сум/, 1,264.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхэд залуучууд ахмадын хөгжлийн барилга /УБ, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/-ыг ТӨБЗГ-ын "Орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 582, 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 789 дүгээр тогтоолуудаар Булган аймгийн болон Нийслэлийн өмчид шилжүүлэх шийдвэрүүдийг хэрэгжүүлээгүй ашиглагч байгууллагад шилжүүлж бүртгүүлэх арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-т "Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана." заалтууд болон ТӨБЗГ-ын 2025 оны 582, 789 дүгээр тогтоолуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын 2025 оны 582, 789 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлж, барилгыг бусад эргэлтийн хөрөнгийн данснаас хасаж, ашиглагч байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авах.

5.3. Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил

5.3.1 ГБХНХЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данс:

ГБХНХЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данстай холбоотой илэрсэн 457.3 сая төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах зөвлөмж өгсөн. Үүнд:

Илрүүлэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн Сүхбаатар дүүргийн хүүхэд залуучуудын зуслан /УБ, НД/ 4,105.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 457.3 сая төгрөгөөс чанарын баталгааны үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулалгүйгээр улсын төсөвт төвлөрүүлсэн нь гүйцэтгэгчийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлийг бий болгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:", засгийн газрын 2023 оны "журам шинэчлэн батлах тухай" 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам"-ын 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ баримт бичиг акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэж заасныг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай тооцоо нийлэн, гүйцэтгэгчийн үлдэгдэл санхүүжилтийг буцаан авах арга хэмжээг зохион байгуулах.

5.3.2 ГБХНХЯ-ы хөрөнгө оруулалт:

ГБХНХЯ-ны хөрөнгө оруулалтын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 31,535.8 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс 22,424.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 9,111.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.3.2.1. Албан шаардлага:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2024, 2025 онд хэрэгжиж дууссан нийт 21,119.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, ажлын гүйцэтгэл дутуу, удаашралтай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;”, Монгол Улсын 2024, 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024, 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гэрээний биелэлтийг хангаж ажиллах, бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, ашиглагч байгууллагад шилжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3.2.2. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

Илрүүлэлт: Барилгын ажил дууссан, барилга хүлээн авах улсын комисс ажилласан боловч ТӨБЗГ-ын шийдвэр гараагүй БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан 9,111.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн барилга" байгууламж бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
II. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ													
1	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар	3	9,222.6			3	9,222.6	3	9,222.6				
2	Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газар	2	580,096.2			2	580,096.2	2	580,096.2				
	ТТЗ-ийн алдааны дүн	5	589,318.8	-	-	5	589,318.8	5	589,318.8	-	-	-	-
III. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН													
1	Нийгмийн халамжийн төв сан	2	1,249.8			2	1,249.8	2	1,249.8				
2	Хүүхдийн төлөө сан	3	9,882,059.2			3	9,882,059.2	3	9,882,059.2				
	ДҮН	5	9,883,309.0	-	-	5	9,883,309.0	5	9,883,309.0	-	-	-	-
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа байгууллагууд													
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан-Төв сан	8	272,849,087.4	8	272,849,087.4			8	272,849,087.4				
2	Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	455,536.0			1	455,536.00	1	455,536.0				
3	Баянхонгор аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	42,458.0	1	20,600.00	1	21,858.00	2	42,458.0				
4	Дархан аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	84,000.0	1	84,000.00			1	84,000.0				
5	Говьсүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,120.0			1	1,120.00	1	1,120.0				
6	Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	181,397.4			2	181,397.40	2	181,397.4				
7	Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	42,404.7			2	42,404.70	2	42,404.7				
8	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	1,363,275.6	2	236,048.90	1	1,127,226.70	3	1,363,275.6				
	ХЭДС-ийн харьяа байгууллагуудын алдааны дүн	20	275,019,279.1	12	273,189,736.3	8	1,829,542.8	20	275,019,279.1				
	ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН АЛДААНЫ ДҮН	25	284,902,588.1	12	273,189,736.3	13	11,712,851.8	25	284,902,588.1				
IV. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	6	513,005.7			6	513,005.7	6	513,005.7				
2	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл мэндийн төв	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0				

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Хөдөлмөр нийгэм хамгаалал, сургалт судалгааны хүрээлэн	5	25,043.6			5	25,043.6	5	25,043.6				
	ТШЗ-ийн алдааны дүн	12	543,049.3	-	-	12	543,049.3	12	543,049.3	-	-	-	-
Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллагууд													
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	3	3,115.4	2	1,515.0	1	1,600.4	3	3,115.4				
2	Багануур дүүргийн НДГ	1	158.2	1	158.2			1	158.2				
3	Налайх дүүргийн НДГ	3	6,186.9	2	1,213.0	1	4,973.9	3	6,186.9				
4	Сонгинохайрхан дүүргийн НДГ	4	214,007.7			4	214,007.7	4	214,007.7				
5	Хан-Уул дүүргийн НДГ	2	171,963.0			2	171,963.0	2	171,963.0				
6	Чингэлтэй дүүргийн НДГ	1	6,099.4			1	6,099.4	1	6,099.4				
7	Баянхонгор аймгийн НДГ	1	3,255.1	1	3,255.1			1	3,255.1				
8	Баянхонгор аймгийн НДГ	1	1,277.7			1	1,277.7	1	1,277.7				
